

ТӨРӨӨС АРИЛЖААНЫ ТЕЛЕВИЗҮҮДЭД ОЛГОЖ БУЙ ДАВУУ БАЙДАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Д.Идэржаргал*, Б.Пүрэв**

*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн дэд профессор, доктор (Ph.D)

**МУИС-ийн, УТСОУХНУС-ийн Улс төрийн мэдээлэл харилцаа хөтөлбөрийн магистрант

Түлхүүр үгс: Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, арилжааны телевизүүд, давуу байдал, хураамж, үзэгчид

Хаант засаг, коммунист дэглэм, дарангуйлалт нийгмийн аль ч үед тухайн орны төрөөс хэвлэл мэдээллийг эрхшээл, нөлөөндөө байлгаж, олон нийтийн санаа бодлыг удирдах, хянах хэрэгсэл байлгаж ирсэн. Төрийн энэ сонирхлыг ардчилсан орнуудад хуулиар тогтоон барихыг хичээдэг. Хэвлэл мэдээллийг төрөөс салгах, хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах, олон нийтийн үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хангахад чиглэсэн алхмууд хийгддэг. Гэсэн хэдий ч төрөөс хэвлэл мэдээллийг шууд хяналтандаа авах бус ямар нэг хэлбэрээр давуу байдал эсвэл сул тал үүсгэж, түүгээрээ дамжуулан нөлөөндөө оруулсаар байна. Тухайлбал сүүлийн жилүүдэд “хаалтын гэрээ” байгуулах замаар хэвлэл мэдээллийг худалдан авч байна гэж олон нийт шүүмжлэх болов. “Захиалагч талын нэр хүндэд харшлах

аливаа сөрөг мэдээ мэдээллийг захиалагч талд мэдэгдэх, нэвтрүүлэхгүй байх үүрэг хүлээнэ” хэмээх заалтыг “Хаалтын гэрээ” гэдэг нэр томъёогоор ойлгож болно”. (Э.Хосбаяр, 2022) гэжээ. Энэхүү өгүүлэлдээ “хаалтын гэрээ”-ний тухай хөндөх гэсэнгүй. Харин түүний хэв шинжийг агуулсан хууль баталж, нөлөө бүхий хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд давуу байдал олгож, эргээд улс төрийн манипуляци хийх дэд бүтэц болгож буй жишээг тайлбарлахыг зорилгоо. УИХ-аас 2019 онд баталсан Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн холбогдох заалтаар хэрхэн телевизүүдэд давуу байдал үүсгэсэн болон хуулийн хэрэгжилт ямар байгаа талаар оролцогч талуудтай ганцаарчилсан ярилцлага хийж, бусад орнуудын өргөн нэвтрүүлгийг дэмжих бодлого, холбогдох судалгаа, мэдээлэлд дүн шинжилгээ хийв.

Юуны өмнө үзэл суртал, улс төрийн манипуляци ба давуу байдал, монопольтой холбогдох асуудал болон телевизийн салбарын онцлог,

хөгжлийн талаар холбогдох үзэл баримтлал, мэдээллээс авч үзье.

Анх XVIII зуунд Францын сэтгэгч Дестют де Траси шинжлэх ухааны эргэлтэд “үзэл суртал” хэмээх нэр томъёог оруулж ирсэн бөгөөд тухайн үедээ “үзэл санаануудын тухай шинжлэх ухаан” гэж нэрлэжээ. Америкийн улс төр судлал, мэдээлэл, харилцааны онол, суртал ухуулгаар мэргэжсэн тэргүүлэх судлаач Харолд Ласвелл “суртал нэвтрүүлэг бол хүн амын өргөн хүрээнд үзүүлж буй үзэл санааны нөлөөлөл юм” (Lasswel.H, 1927) гэжээ. Т.Адорно “Авторитари бие хүн” (1950) бүтээлдээ олон нийтийн мэдээллийн хэрэгслийн мэдээллийг эхлээд үзэл бодлын манлайлагчид хүлээн авч, дараа нь агуулгыг өөрчилж, хянан найруулж, мэдээллийн хэрэгслүүдтэй шууд харьцдаггүй нийгмийн идэвх сул хүмүүст түгээдэгт оршдог гэсэн үзэл баримтлалыг дэвшүүлжээ.

Улс төрийн манипуляци (political manipulation) гэдгийг улс төр судлалд хүмүүсийн улс төрийн ухамсар үйл байдлыг өөрийн эрх ашгийн үүднээс далд аргаар удирдах явдал гэж тодорхойлдог. АНУ-ын хэвлэлийн онол, түүхийн судлаач Фредерик Сиберт, Теодор Петерсон, Уилбур Шрамм нар Хэвлэл мэдээллийн дөрвөн онолдоо авторитари, либертари, нийгмийн хариуцлагын, зөвлөлтийн коммунист хэмээн ангилсан. Авторитари үзэл баримтлал нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл зөвхөн хаан, фюрер, эзэн, төр засгийн өмнө хариуцлага хүлээдэг. Либертари үзэл баримтлал нь хэвлэл төр засгийг хянах замаар “дөрөв дэх засаглал”-ын үүргийг гүйцэтгэдэг гэж үздэг байна. Тэгвэл Нийгмийн

хариуцлагын онол нь хэвлэл мэдээлэл нийгмийн эрх ашгийг харгалзан үзэхээс гадна эздээс хараат бус, бие даасан байдалд үйл ажиллагаа явуулах ёстой гэдэгт оршино. Зөвлөлтийн коммунист онолоор бол хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь коммунист намын зэвсэг бөгөөд түүнийг төр, засгийн хяналтын байгууллагууд хатуу хянадаг (Зулькафиль М, 2010) гэсэн байна.

Давуу байдал, монопол, олигополийн тухайд: “Авлигын эсрэг хуулийн 3.1.4-т "давуу байдал" гэж албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласнаар хувь хүн, хуулийн этгээдэд буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг” хэлнэ гэжээ. Ирвинг Фишерийн тодорхойлсноор монополь нь “өрсөлдөөнгүй” зах зээл гэсэн ойлголт бөгөөд монопольчлох гэсэн үг нь өрсөлдөгчдөө боломж олгохгүй байх чадварыг олж авах үйл явцыг илэрхийлдэг. Тэгвэл олигополь нь цөөхөн компани зах зээлийн дийлэнх хувийг эзлэхийг ойлгоно. Энэ бүлэглэл дотор орох ба гарах нь нэлээд бэрхшээлтэй. Шийдвэр гаргалт харилцан хамааралтай.

Харин хэвлэл мэдээллийн салбар дахь конгломераци буюу төвлөрөл гэдэг нь (латинаар conglomeratio буюу “бөөгнөрөх, цуглуулах” гэсэн үнээс гаралтай) Энэ нь янз бүрийн мэдээллийн хэрэгслүүдийг нэгтгэх, худалдан авах замаар цөөхөн хэдэн эздийн гарт төвлөрөх үйл явц юм. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд дотроос үзэгчдийн 70 хувийг тогтмол барьж чаддаг төрөл бол телевиз юм. Мөн олон улсын судлаачид том нутаг дэвсгэртэй болон хүн амын нягтрал багатай улс орнуудын медиа зах

зээлд ТВ-ийн салбарын хувь, хэмжээ өндөр байдаг гэж дүгнэсэн (Максима Медиа ХХК, 2006) байна.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой үнэлгээ, дүгнэлт, бусад орнуудад хэрхэн зохицуулсан талаарх харьцуулсан судалгаа, холбогдох байгууллагуудын мониторинг зэрэг мэдээллүүдийг авч үзлээ. Тухайлбал Цахим хөгжил, харилцаа холбооны яам Өргөн нэвтрүүлгийн бодлогын судалгааны төслийг /2023/ БНСУ-ын KISDI байгууллагаар гүйцэтгүүлсэн байна. Мөн Хүмүүнлэгийн Ухааны Их Сургуулийн сэтгүүл зүйн багш, судлаач Д.Оюунбатын “Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн шинжилгээ” бүтээл бий. “Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ”-г “Заяа энд Золоо” ХХК гүйцэтгэсэн байна. Максима Медиа компанийн судлаачид 2016 онд “Телевизийн салбарын зах зээлийн зохицуулалтад гүйцэтгэх үзэгчийн судалгааны ач холбогдол, үүрэг” сэдэвт судалгаа хийжээ. Мөн Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны сар, улирал тутмын мониторинг чухал үүрэгтэй. Энэ мэтээр судалгаанд шууд хамааралтай болон бусад эх сурвалжууд, холбогдох материалуудыг ч авч үзсэн болно.

Өргөн нэвтрүүлгийн тухай хууль дахь давуу байдлын асуудал ба бусад орны жишээтэй харьцуулсан шинжилгээ:

Өргөн нэвтрүүлгийн тухай хууль /ӨНХТ/-д шинэчилсэн найруулга хийх төслийг Засгийн газар санаачилж УИХ-д /2016.12.28/ өргөн мэдүүлсэн юм. Хуульд өөрчлөлт оруу-

лах үндэслэл, шаардлагыг ерөнхийд нь ингэж тодорхойлжээ:

1. Өргөн нэвтрүүлгийн салбарт МҮОНРТ-ээс бусад 250 орчим оролцогчдын эрх зүйн орчин тодорхойгүй
2. Нийгмийн оюун санааг цочирдуулсан мэдээллийг хязгаарлаж, стандарт тавих шаардлагатай.
3. Үндэсний уламжлал, ёс заншлыг хадгалсан, Монголын түүх, соёлын холбогдолтой бүтээлүүд бага байгаа нь соёлын дархлаанд сөргөөр нөлөөлж байна.
4. Хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн, хараат бус, бие даасан радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн зах зээлийн шударга өрсөлдөөний таатай орчин бүрдэнэ.
5. Иргэд, байгууллагуудын эрх ашгийг хамгаалах шаардлагатай гэжээ.

ӨНТХуулийн төслийг 2019.12.12-ны өдөр УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанд оролцсон 44 гишүүний 37 нь буюу 84.1 хувь нь дэмжсэнээр хуулийн төсөл батлагдсан байна.

Давуу байдал 1. Үйлчилгээний хөлс буюу “хураамж” авахыг хуульчилсан нь.

Өргөн нэвтрүүлгийн тухай хууль /ӨНХТ/-ийн 20.5.3. Өргөн нэвтрүүлгийн радио, телевизүүд нь энэ хуулийн 6.1.2-т заасан үйлчилгээний үндсэн багцын өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний орлогын 15 хувиас доошгүй хэмжээгээр өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний хөлс авах; хэмээн хуульчлав.

Энэ талаар Eguur.mn сайт “Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар Монголын 768 мянган айл өрхийн 82 хувь нь “Univision”, “Skymedia”, “DDish”

зэрэг кабелийн сувгуудаараа дамжуулан телевизүүдэд хураамж төлдөг. Тухайлбал, хувь хүн эзэмшдэг, арилжааны 18 телевизэд нэг өрх дунджаар 2500-3500 төгрөгийг сард төлдөг. 768 мянган өрхийн 82 хувь нь 629,760 өрх болж байна. Сард төлдөг дүнг дундажлан 3000 төгрөг гэж үзвэл нийт нэг тэрбум 889 сая 280 мянган төгрөг болж буй. Харин бүтэн жилд эдгээр 18 телевиз иргэдээс нийтдээ 22 тэрбум 671 сая 360 мянган төгрөгийг иргэдээс босгодог болж байна. Үүнийг арилжааны 18 телевизэд хуваавал нэг телевизэд сард 104 сая 960 мянган төгрөгийг иргэдээс төвлөрүүлдэг гэсэн үг” гэж мэдээлжээ. Анх төлбөр авч эхлэх үед иргэд гэрээнд тусгагдаагүй төлбөрийг гэнэт нэхэмжлэх болсонд дургүйцэж, оператор компани буюу Univision, Ddish, Skymedia зэрэг олон суваг дамжуулагчид руу хандсан боловч энэ төлбөрийг бид биш Монголын Телевизүүдийн холбоо авч байгаа гэсэн тайлбар өгч байв. Хэрэв ӨНТВ хураамжийг төлөхгүй гэвэл гэрээгээ цуцална гэж мэдэгдэж байлаа. Ингээд иргэд ШӨХТГ, Үндсэн хуулийн цэц, УИХ зэрэг байгууллагуудад хандах болсон юм.

Аливаа бараа, үйчилгээний үнэ эрэлт, нийлүүлэлтээр тогтох ёстой. Гэтэл Монголын телевизүүдийн холбоо 15% гэдэг механик заалтыг хуулинд тусгуулж, төрийн оролцоог энэ салбарт шууд оруулж ирсэн гэж дүгнэхээр байна.

2013-2023 оны хооронд ТВ9 телевизийн ТУЗ-ийн даргын албыг хашиж байсан П.Баттөр “Олон сувгийн үйлчилгээ үзүүлж байгаа Univision, Skymedia зэрэг сувгууд телевизүүдийн эфирийг

буюу контент, бүтээлийг хэрэглэгчдэд хүргэж өгөөд орлого олж байгаа. Гэтэл энэ зах зээлд хамгийн чухал оролцогч болох контент үйлдвэрлэгч телевизүүд тухайн орлогоос хувь хүртэх боломжгүй байсан. Тэгэхээр Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн анхны санаа бол хэрэглэгч нэмэлт төлбөр төлөхгүй. Харин олон суваг дамжуулагчдын ашгаас хуваалцах зорилгоор хуулийн зохицуулалт хийх тухай яригдсан. Гэхдээ юуг нь нуух вэ. Монголын нийгэмд хэн мөнгөтэй, хөрөнгөтэй, эрх мэдэлтэй, улс төрд нөлөөтэй этгээтүүд хуулиа захиалж батлуулдаг болчихсон. Энэ жишгээр яг хуулийг батлахдаа хэрэглэгчээс мөнгө авахаар зохицуулчихсан юм. Гол асуудал энд л байгаа” (Баттөр П, 2024) хэмээн тайлбарласан юм.

ЦХИХХЯ-ны захиалгаар “Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ”-г “Заяа энд Золоо” ХХК гүйцэтгэсэн байна. Тус үнэлгээний тайланд “Шууд хэрэглэгчээс нэмэлт төлбөр авч буй бөгөөд Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн холбоо /ОСДҮЭХ/ болон Монголын телевизүүдийн холбоо /МТХ/ аль аль нь хуулийн заалтыг өөрт ашигтайгаар тайлбарлаж, хариуцлагын асуудлыг өөрсдөөсөө холдуулж байна. Хуулийн заалтыг нэг мөр тодорхой болгож аутентик тайлбар хийх, эсвэл хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай” (Золжаргал Э, 2023) гэжээ. Цахим хөгжил, харилцааны холбооны сайд асан Ж.Эрхэмбаатартай (2024.03 сард) хийсэн уулзалтын үеэр “Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар бодлогын судалгаа хийлгэж байна. Манай яамнаас хуулийн төсөл санаачлаад, ажлын

хэсэг ажиллаж байгаа. Уг хуульд өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагууд байна. Тухайлбал Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний хураамжийг эцсийн хэрэглэгч буюу үзэгчдээс авч буй асуудал” хэмээсэн юм.

ӨНТХ-ийн холбогдох заалт Үндсэн хууль зөрчсөн гэж үзэн Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргасан иргэдийн төлөөлөл, Хуульч Б.Мэргэн “Иргэдийн халааснаас яагаад татвар дээр нэмэх нь давхар татвар авч байгаа юм бэ? Хэрэв Өргөн нэвтрүүлгийн салбарыг төр заавал дэмжих ёстой юм бол төсвийн хөрөнгөөр юм уу бусад арга хэлбэрээр дэмжих боломжтой. Харин иргэдэд дахин ачаа үүрүүлж, давхар татвар авч байгаа нь буруу гэж үзэж байна” (Мэргэн Б, 2024) гэсэнтэй санал нэгтэй байна.

Давуу байдал 2. Монголын телевизүүдийн холбоо болон түүний гишүүн 18 телевизийг онцгойлон авч үзэх нь.

ӨНТХ-ийн 20.6. Өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн заавал гишүүнчлэлтэй, нийтийн эрх зүйн хуулийн этгээд болох Монголын телевизүүдийн холбоо /цаашид "Холбоо" гэх/ нь энэ хуулийн 20.5.3-т заасан хөлсийг төвлөрүүлж, өргөн нэвтрүүлгийн телевизийн үзэлтийн судалгааг үндэслэн гишүүдэд хуваарилна. гэсэн энэхүү заалтаар нэг байгууллагыг онцгойлон авч үзжээ.

Энэ тухай “Ардчиллын боловсрол” төвийн тэргүүн Г.Ундрал “1997 онд Төрийн бус байгууллагын тухай хууль батлагдсан. Тэрнээс хойш 30 гаруй жилийн хугацаанд төрөөс төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн холбоодуудад хариуцуулах тохиолдол мэр сэр гарч байсан. Гэтэл

яагаад хуулинд Монголын Телевизүүдийн Холбоо нэртэй нэг ТББ-ыг нэр зааж оруулав. Ийм тохиолдлыг би анх удаа харж байна. Монголд 30 гаруй мянган ТББ бий. Яагаад ганцхан ТББ-д ингэж давуу эрх олгож байгаа юм?” (Ундрал Г, 2023) гэжээ.

Мөн хуулинд Монголын телевизүүдийн холбоо нь “заавал” гишүүнчлэлтэй байхаар заасан байдаг. Энэ талаар Монголын Хэвлэлийн хүрээлэнгийн гүйцэтгэх захирал М.Мөнхмандах “Төр засгаас хэвлэл мэдээллийн байгууллагуудад заавал гишүүнчлэлтэй холбоо, эвсэл, ямар нэгэн байгууллага байгуулахыг шаардах ёсгүй юм. Гэтэл Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд Монголын телевизүүдийн холбоо нь заавал гишүүнчлэлтэй байна гээд заачихсан. Энэ бол Хэвлэлийн эрх чөлөө, хараат бус байдлын эсрэг заалт” (Мөнхмандах М, 2023) хэмээн тодотгосон байна.

“Монголын хэвлэл мэдээлэл - Өнөөдөр” /2024/ мониторингийн тайланд тусгаснаар манай улсын хэвлэл мэдээллийн салбарт нийт 434 аж ахуй нэгж ажиллаж байна. Гэтэл ӨНТХ-иар зөвхөн Монголын телевизүүдийн холбоог онцгойлон авч үзсэн бөгөөд ӨНТХ-иар дэмжлэг авах боломжтой бусад телевиз, радио хүртэл “хасагдсан” байгаа нь анхаарал татаж байгаа юм. Тодруулбал Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшигч нийт 241 ААН байгаа бол хуульд заасан үйлчилгээний хураамжийг 18 телевизэд л хуваарилдаг байна.

Өргөн нэвтрүүлгийн тухай хууль батлагдсанаас /2019.12.12/ хойш Монголын телевизүүдийн холбоо

орон нутгийн 52 телевизийг өөртөө нэгтгэсэн боловч үйлчилгээний хөлснөөс орон нутгийн телевизүүдэд хувиарлахгүй байгаа нь гол асуудал болж байна гэж Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээнд (Золжаргал Э, 2023) дурджээ.

ӨНТХ-иар “хураамж”-ийн дэмжлэг авч буй, Монголын телевизүүдийн холбооны гишүүн 18 телевиз нь: Монгол, ТВ25, UBS, ТВ5, ТМ, ТВ8, С1, ТВ9, Central, NTV, Eagle, Тэнгэр, ETV, Малчин, Сүлд телевизүүд юм.

№	Ангилал	УБ	Орон нутаг
1.	Олон нийтийн телевиз	5	
2.	Өргөн нэвтрүүлгийн телевиз	18	48
3.	Арилжааны телевиз	53	
4.	Төлбөртэй телевиз	21	
5.	Олон нийтийн радио	4	
6.	Арилжааны радио	35	28
7.	Олон суваг дамжуулагч	12	16
8.	Газрын сүлжээ дамжуулах үйлчилгээ	1	
Нийт		149	92

Хүснэгт №1. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийн тоо. Эх сурвалж: Харилцаа холбооны зохицуулах хороо.

Давуу байдал 3. Үндсэн багцын эхэнд байршуулсан нь.

“ӨНТХ-ийн 26.7. Үндэсний олон нийтийн телевиз болон өргөн нэвтрүүлгийн телевизийн сувгууд нь олон суваг дамжуулах үйлчилгээний үндсэн багцын эхэнд байна” гэж заасан.

Энэ заалт хэрэгжиж эхэлснээр өмнө нь байсан сувгийн байршлууд үндсээрээ өөрчлөгдсөн юм. Хууль батлагдсанаар сувгийн 1-рт МҮОНРТ, түүнээс хойш дээрх 18 телевиз дарааллан байршихаар болсон билээ. Энэ талаар Монголын Арилжааны телевизүүдийн холбооны /МАТХ/ зүгээс “Өргөн нэвтрүүлгийн 18 телевиз үндсэн багцын эхэнд байршсанаар бид зар сурталчилгааны орлогогүй болсон. Үүнээс үүдэн шударга өрсөлдөх боломж нөхцөлгүй болсон. Өргөн нэвтрүүлгийн 18 телевизүүдэд илүү их боломж олгосон” (Золжаргал Э, 2023) гэжээ.

Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн Г.Нарантуяа “Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар телевизүүдийг хоёр ангилж, нэг хэсэгт нь илт давуу байдал олгосон. Дэлгүүрт бараа бүтээгдэхүүнийг хаана байршуулахаас хамаарч худалдан авагчдын сонголтод нөлөөлдөг гэсэн судалгаа бий. Тэгвэл 18 телевиз сувгийн эхэнд байрших боломж өгчихсөн. Мөн 1998 оны Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулиар төрийн оролцоог хумьж өгсөн байтал энэ хуулиар буцаагаад эрх хэмжээгээ нэмэгдүүлсэн байна.” (Нарантуяа Г, 2023) гэсэн байр суурийг илэрхийлжээ.

Монголын Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн холбооны зүгээс ч мөн “Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд дугаарлалтын дарааллыг МҮОНРТ, Өргөн нэвтрүүлгийн телевиз, Арилжааны телевиз, гадаад суваг гэж тусгайлан хуульчилж өгсөн нь Өрсөлдөөнд харш үйлдэл болсон

болно” (Золжаргал Э, 2023) хэмээн хүлээн зөвшөөрсөн байна.

Давуу байдал 4. Өргөн нэвтрүүлгийг хөгжүүлэх сан байгуулсан нь.

“ӨНТХ-ийн 20.2. Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх санг улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэсэн заалт бий. Засгийн газрын дэргэдэх тусгай сангаар дамжуулан Өргөн нэвтрүүлгийг хөгжүүлэхэд зориулсан мөнгөн дэмжлэгийг олгож байна. Жилд 2 орчим тэрбум төгрөгийн хөрөнгийг Монголын Телевизүүдийн холбоо болон Арилжааны телевизүүдэд олгодог байна. Энэ сан нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн зорилго, үйлчилгээний орлогын дэмжлэгтэй давхцаж буй талаар судлаачид байр сууриа илэрхийлдэг билээ.

Давуу байдал 5. Телевиз үзэлтийн судалгаа болон контентонд тавих шаардлага буюу хариуцлагын асуудал орхигдсон.

“ӨНТХ-ийн 20.6. Өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн заавал гишүүнчлэлтэй, нийтийн эрх зүйн хуулийн этгээд болох Монголын телевизүүдийн холбоо /цаашид “Холбоо” гэх/ нь энэ хуулийн 20.5.3-т заасан хөлсийг төвлөрүүлж, өргөн нэвтрүүлгийн телевизийн үзэлтийн судалгааг үндэслэн гишүүдэд хуваарилна” гэжээ.

Энэ талаар Монголын телевизүүдийн холбооны гүйцэтгэх захирал А.Баярбаттай ярилцахад “Телевизийн үзэлтийн судалгааны хувьд Максима медиа ХХК хийдэг байсан ч одоо хийхээ больсон. Монголын телевизүүдийн холбоо одоогийн байдлаар өөрт төвлөрсөн үйлчилгээний хөлсийг зөвхөн Өргөний 18 телевиз л тэнцүү хувааж авч байгаа орон нутгийн телеви-

зүүдэд хувиарлах боломжгүй байна. Үзэлтийн судалгааг авах талаар олон суваг дамжуулагч нартай холбогдож албан бичиг өгсөн боловч хариу өгөөгүй. Зарим нь техникийн боломжгүй гэдэг, зарим нь хөрөнгө оруулалт хийсний үндсэн дээр гаргах боломжтой гэсэн хариу өгсөн” (Золжаргал Э, 2023) гэж тайлбарлажээ.

ТВ9 телевизийн ТУЗ-ийн дарга асан П.Баттөр “Хэн их үзэгчтэй нь их мөнгө, хэн бага үзэлттэй нь бага мөнгө авах буюу үзэлтийн судалгаанд үндэслэж байж орлогыг хуваарилна гэсэн заалт хуульд байгаа. Гэтэл 4 жилийн хугацаанд хуулийн энэ заалт хэрэгжээгүй. Үнэндээ 18 телевиз дотор редакцтай, редакцгүй, 100 хүнтэй мэргэжлийн багтай, эсвэл хэдхэн хүн ажилладаг гээд маш их ялгаатай телевизүүд байгаа боловч орлогыг жигд хувааж авч байгаа. Хуулийн амин сүнс болсон заалтыг одоо болтол хэрэгжүүлэхгүй байна” (Баттөр П, 2024) гэв.

Монгол Улсад өргөн нэвтрүүлгийн телевизүүд нь үйлчилгээний орлогыг шударга хуваарилж буй эсэх нь ноцтой, төвөгтэй асуудал болоод байна. Онолын хувьд олон суваг дамжуулагч болон өргөн нэвтрүүлэг бэлтгэгч (телевиз) нь орлогоо бие даасан гэрээгээр өөрсдөө шийдэх ёстой. Энэ бол тэдний бизнесийн харилцааны асуудал юм. Өргөн нэвтрүүлгийн бодлогын судалгаа хийсэн БНСУ-ын KISDI байгууллага “Монгол Улсад одоогоор олон сувгийн үйлчилгээ эрхлэгчдээс үйлчилгээний орлогын 15-аас доошгүй хувийг өргөн нэвтрүүлгийн телевизүүдэд өгөх хууль хэрэгжиж байна. Энэ хэмжээ шударга байгаа эсэхийг Харилцаа холбооны зохицуулах хороо

дахин нягтлахыг зөвлөж байна. Үүнийг хийхийн тулд зах зээлийн үнэлгээ, үзэлтийн хэмжээг гаргасан нарийвчилсан судалгаа шаардлагатай” (Korea Information Society Development Institute, 2023) гэжээ.

ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН КОНТЕНТЫН АГУУЛГА БА ХУУЛИЙН ХЭРЭГ-ЖИЛТ. Өргөн нэвтрүүлгийн тухай

хууль болон ХХЗХ-ноос гаргасан холбогдох журамд зааснаар телевизүүд жилд үндэсний түүх, соёл, уламжлалтай холбоотой 200 цагийн нэвтрүүлэг жилд, танин мэдэхүйн сэдэвт 180 цагийн нэвтрүүлэг болон хүүхдэд зориулсан нэвтрүүлгийн гээд тус тус шаардлага тавьсан байдаг. Харин хууль, журмын хэрэгжилт хангалтгүй байгаа нь ХХЗХ-ны мониторингийн тайлангаас харж болно. Мөн хөтөлбөрийн

шаардлага хангаагүй телевизүүдэд хэрхэн хариуцлага

тооцох нь тодорхойгүй бөгөөд тийм механизм бүрдээгүй байна.

Судлаач Д.Оюунбат “Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн шинжилгээ”-ндээ ТВ5, ETV, SBN телевизүүдийг сонгон авч 2023.04.28-наас 05.04-нийг хүртэлх 7 хоногийн хөтөлбөрт анализ хийжээ. ТВ5 телевизийн 7 хоногийн эфирт 38

нэвтрүүлгийн дугаарууд болох нийт 8265 минутын хөтөлбөрийг шүүж үзэхэд жишээлбэл тус телевизийг гэр бүлийн хамт эзэмшигч УИХ-ын гишүүн Д.Сарангэрэлийн тойрогтоо хийсэн ажлыг “Хүмүүс энэ цагт” нэвтрүүлгийн нэрэн дор нийт 32 удаа давтан гаргасан байна. ETV телевизийн 7 хоногийн эфирт 33 нэвтрүүлгийн дугаарууд болох нийт 7095 минутын хөтөлбөрийг шүүж үзэхэд “Хүнсний аюулгүй байдлын цаг”, “МУ-ын ерөнхийлөгч У.Хүрэлсүх” нэвтрүүлгүүд нь 22 удаагийн

давамжтайгаар нийт 380 минут, эфирийн цагийн 5.4 хувийг эзэлсэн нь зөвхөн ерөнхийлөгчийн суртал ухуулга байв. SBN телевизийн 7 хоногийн эфирт 28 нэвтрүүлгийн дугаарууд болох нийт 6545 минутын хөтөлбөрийг шүүж үзэхэд 1520 минут буюу эфирийн цагийн 23.2 хувьд

олон ангит кинонууд гаргасан байх жишээтэй (Оюунбат Д, 2023) байгааг судалгаандаа онцолжээ.

Харилцаа холбооны зохицуулах хорооны зүгээс тайлбарлахдаа “Монголын телевизүүдийн холбооны үйл ажиллагааг хянах, хуулийн хэрэгжилтийг шаардах, тайланг нь гаргуулж авна гэх мэт заалт, чиг үүрэг

«

Өргөн нэвтрүүлгийн тухай хууль болон ХХЗХ-ноос гаргасан холбогдох журамд зааснаар телевизүүд жилд үндэсний түүх, соёл, уламжлалтай холбоотой 200 цагийн нэвтрүүлэг, танин мэдэхүйн сэдэвт 180 цагийн нэвтрүүлэг болон хүүхдэд зориулсан нэвтрүүлгийн гээд тус тус шаардлага тавьсан байдаг. Харин хууль, журмын хэрэгжилт хангалтгүй байгаа нь ХХЗХ-ны мониторингийн тайлангаас харж болно. Мөн хөтөлбөрийн шаардлага хангаагүй телевизүүдэд хэрхэн хариуцлага тооцох нь тодорхойгүй бөгөөд тийм механизм бүрдээгүй байна

»

хуулинд байхгүй. Ер нь Өргөн нэвтрүүлгийн телевизүүдэд хэрхэн хариуцлага тооцох асуудал тодорхойгүй байна. Тухайлбал үндэсний түүх, соёлын бүтээл үйлдвэрлэх үүрэгтэй гэж үзье. Гэтэл тэр заалтаа хэрэгжүүлээгүй бол яах юм? Зөрчлийн хуулиар торгуулийн арга хэмжээ авах юм уу? Эсвэл тусгай зөвшөөрлийг нь цуцлах юм уу? Энэ бүхэн тодорхойгүй байгаа” (Тогтохсүрэн Н, 2024) гэжээ.

Глоб интернэшнл төвийн хуульч Галбаатар “Өргөн нэвтрүүлгийн тухай хууль үйлчилж эхлээд 4 дэх жилдээ орж байна. Өргөн нэвтрүүлгийн телевизүүд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байгаа нь олон судалгаанд харагдаж байгаа. Ялангуяа сонгуулийн үеийн мониторингуудыг харахад телевизүүд мэдээллийг тэнцвэртэй, олон ургальч байдлаар хүргэхгүй, хэт нэг талд их цаг оноодог тал байна. Мөн хуулийн хэрэгжилтийг хянах ёстой Харилцаа холбооны зохицуулах хороо ажлаа сайн хийхгүй байна аа гэсэн үг” (Галбаатар Л, 2024) гэж үзжээ.

УИХ-ын гишүүн Д.Энхтуяа: Энэ хууль анхнаасаа улс төрийн захиалгатай байсан. Өнөөдөр 18 телевиз нэг командаар нэг өнгө аясаар мэдээлэл дамжуулдаг болсон. Үүний цаана мэдээлэлтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх зэрэг иргэний үндсэн эрх зөрчигдөхөөс гадна хэрэглэгч, үзэгчийн эрх ашгийг ноцтой зөрчсөөр байна. Иймд цаашид МҮОНРТ нь олон нийтийн, бусад телевизүүд нь арилжааны статусаар буюу зах зээлийнхээ зарчмаар явах нь зөв (Энхтуяа Д, 2024) гэжээ. Өнөөдөр олон улсад төлбөрт телевиз гэхээс илүү Video-on-demand (VOD)-ийг

ашигладаг болсон байна. Манай улсад тухайлбал Look tv, ORI, SkyGO, VOO service of mobinet, MOTV зэрэг нь VOD-д ангилалд багтах юм.

ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦЭД ХАНДСАН НЬ. Б.Пүрэв миний бие 2023 оны 4 сарын 18-ны өдөр иргэний хувиар ӨНТХ-ийн холбогдох заалт Үндсэн хууль зөрчсөн асуудлаар Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргасан болно. Мөн иргэн Б.Хонгорзул, Б.Мэргэн, Б.Ариунтуяа нар мэдээлэл гаргасан байна. Үндсэн хуулийн цэц иргэдийн мэдээллийг хүлээн авч үзээд ШӨХТГ-аас тайлбар, мэдээлэл хүссэн юм. ШӨХТГ-аас 2023 оны 1 сарын 11-ны өдөр 01/80 дугаар бүхий албан бичигт дурдсан агуулгыг товчлон хүргэвэл:

1. Хэрэглэгчийн эрх ашгийг зөрчсөн: ӨНТХ-д үйлчилгээний хөлсийг үндсэн багцын төлбөрөөс авна гэж заасан боловч ХХЗХ-ны 2020.09.22-ны 62-р тогтоолоор баталсан “Олон суваг дамжуулах үйлчилгээний үндсэн багцын зохицуулалтын журам”-аар хэрэглэгчийн хүсэлтийг үл харгалзан, төлбөр нэмэгдүүлэн авсан байна.
2. 18 телевизэд илт давуу байдал үүсгэсэн: ӨНТХ-ийн 4.1.7-д “арилжааны радио, телевиз” гэж хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай, ашгийн төлөө үйл ажиллагаа эрхлэх радио, телевизийн үйлчилгээг хэлнэ гэж тодорхойлсон атал Өргөн нэвтрүүлгийн телевизүүдийг МҮОНРТ-тэй адилтган үнэ төлбөргүй дамжуулахаар хуульчилсан нь “Монголын телевизүүдийн холбоо”-д гишүүнчлэлтэй 18

телевизэд илт давуу байдал олгосон байна.

3. Шударга бус өрсөлдөөн бий болгосон: ӨНТХ-ийн 26.7-д “Үндэсний олон нийтийн радио телевиз болон өргөн нэвтрүүлгийн телевизийн сувгууд нь олон суваг дамжуулах үйлчилгээний үндсэн багцын эхэнд байна” гэж заасан нь зах зээлийн шударга бус өрсөлдөөнийг бий болгосон байна гэжээ.

Тэгвэл Үндсэн хуулийн цэцээс 2023.11.15-ны өдөр УИХ-ын дарга Г.Занданшатар болон мэдээлэл гаргасан нэр бүхий иргэдэд хаягласан дугаар 2/466 тоот албан бичигт Өргөн нэвтрүүлгийн тухай хуультай холбогдуулан иргэд мэдээлэл ирүүлсэн байна. Энэ нь УИХ-ын онцгой бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэх асуудал байна гэж үзсэн тул иргэдийн мэдээллийг шилжүүлж буй талаараа мэдэгджээ. Энэ нь Үндсэн хуулийн цэц иргэдийн мэдээлэлд маргаан үүсгэхээс татгалзсан хэрэг бус. Харин асуудлыг өөрөөсөө холдуулсан хэрэг байна гэж хуульч Б.Мэргэн үзэж байлаа. УИХ-ын зүгээс Үндсэн хуулийн цэцэд болон мэдээлэл гаргасан иргэдэд ямар нэгэн тайлбар, мэдээлэл өгөөгүй байна.

УИХ-Д ХАНДСАН НЬ.

Судлаач нь УИХ-ын Нийтийн өргөдлийн цахим системд “ӨНТХ-ийн холбогдох заалтыг хүчингүй болгох”-ыг хүссэн өргөдөл санаачилсан. Нийтийн өргөдөлд: “Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7, 4.1.21 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.2 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.5.3, 20.5.4 дэх заалт, мөн зүйлийн 20.6,

20.7, 20.8 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.5, 26.7 дахь хэсэгт өөрчлөлт оруулж, иргэд, телевиз үзэгчид IPTV үйлчилгээ эрхлэгчдээр дамжуулан Монголын телевизүүдийн холбоо, түүний гишүүн 18 телевизэд хураамж төлөхгүй байхаар зохицуулж өгнө үү” гэсэн хүсэлт бүхий нийтийн өргөдлийг нэг сарын хугацаатай зарласан болно. Өргөдөлд нийт **12.033** иргэн цахимаар гарын үсгээ зурж, саналаа өгсөн юм. Иргэдийн идэвх оролцоо ямар байсныг тодруулах зорилгоор бусад өргөдлүүдтэй харьцуулан үзсэн юм. УИХ-ын Нийтийн өргөдөл хүлээн авах <https://petition.parliament.mn/> системд нэг жилийн хугацаанд /2024.10.17-ноос 2024.11.16/ иргэд нийт 171 удаагийн өргөдөл санаачилсан байна. Үүний 90 гаруй хувь нь мянга хүрэхгүй санал авчээ. Нийтийн өргөдөл нь 33.000, 70.000, 100.000 хүний санал авах гэсэн гурван ангилалтай бөгөөд энэхүү дүн шинжилгээнд дээрх ангилалд багтах, бүх өргөдлийг хамруулсан болно. Нийт 171 удаагийн санал асуулгаас ердөө 6% нь буюу 10 өргөдөл 10.000-аас дээш тооны санал авчээ. Хамгийн өндөр санал авсан дээрх 10 өргөдөл дотор “Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар иргэд 18 телевизэд хураамж төлж буй зохицуулалтыг хүчингүй болгох” тухай нийтийн өргөдөл багтсан байна.




График №1. 171 нийтийн өргөдлийн са-

нал авсан байдал. Эх сурвалж:
<https://petition.parliament.mn/>.

Цахим гарын үсэг авах <https://petition.parliament.mn/> систем нь иргэдийн мэдээллийг баталгаажуулах DAN систем болон E-mongolia гэх мэт хоёрдогч, гуравдагч системээр дамжих, тусгай дугаарт мессеж илгээх зэрэг олон үйлдлийг шаарддаг. Дээрх үйлдлийг гүйцэтгэсэн ч эргээд санал асуулга нь олдохгүй болох зэрэг ихээхэн хүндрэлтэй байгааг оролцогчид хэлж байлаа. Гэсэн хэдий ч хамгийн олон санал авсан өргөдлийн нэг болж чадсан нь олон нийт энэхүү өргөдлөөр дамжуулан эсэргүүцлээ идэвхтэй илэрхийлж буйг харж болох юм.

ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН БОДЛОГО ОЛОН УЛСАД. Телевиз үзэлтийн судалгаа

авч буй байдал: Олон улсын хэмжээнд Телевиз үзэлтийн судалгаа хийдэг хэд хэдэн компани байдгаас Кантар Медиа, Nielsen Media Research (NMR), германы GFK нар үйл ажиллагааны цар хүрээгээр хамгийн том нь юм. Кантар Медиа компани гэхэд дэлхийн 60 гаруй улс оронд үйл ажиллагаагаа явуулж байна. БНСУ-ын KISDI байгууллага Монгол улсын өргөн нэвтрүүлгийн салбарт хийсэн бодлогын судалгаандаа “Хамгийн наад зах нь үзэлтийг судалгааг тогтмол хийж байж өргөн нэвтрүүлгийн салбарт баримтлах бодлого, тусгай зөвшөөрөл олгох үйл явц эрүүлжих болно. Өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөл авах, сунгахад арилжааны радио, телевизүүд ямар бодлогын зорилгыг хэрэгжүүлэх үүрэг нь

тодорхойгүй байна. Угтаа бол тусгай зөвшөөрөл олгох нь зөвхөн захиргааны журам биш, бодлогын үр дүнтэй хэрэгсэл байх ёстой юм (Korea Information Society Development Institute, 2023) гэжээ.

Максима Медиа компанийн судлаачид 2016 онд “Телевизийн салбарын зах зээлийн зохицуулалтад гүйцэтгэх үзэгчийн судалгааны ач холбогдол, үүрэг” гэсэн судалгаа хийсэн юм. Энэ судалгааны хүрээнд газар зүйн байрлал, улс төрийн тогтолцоо, үндэсний онцлог зэргийг нь харгалзан 28 улсыг сонгон авч үзсэн байна. Үзэгчийн тоог тооцдог үнэлгээнд ашигладаг систем олон улсад хөгжөөд 30 гаруй жил байна. Салбар хүсвэл, хичээвэл хөгжих, чанаржих боломж нь байгаа. Гэтэл зах зээлийн тоглогчид, тэр тусмаа ТВ-үүд өөрсдийгөө л аргацайлдаг системдээ дасан зохицож, тэндээ тухлан оршин тогтносоор байна. Энэ салбар ямар ч хөгжил дэвшил байхгүй, эсрэгээрээ доройтож байгаагаа ухамсарлах цаг аль хэдий нь болсон. (Максима Медиа ХХК, 2006) судалгаанд дүгнэсэн байна.

Үндэсний контентыг дэмжиж буй байдал: Европын холбооны “Аудиовизуал медиа үйлчилгээний заавар”-т гишүүн орнуудаас Европын контентод тодорхой хэмжээний эфирийн цаг хуваарилахыг шаарддаг. Европын Холбооны орнуудын дундаас Франц нь агуулгын шаардлагыг хамгийн өндөрт тавьдаг. Франц нь контентын агуулгад хамгийн багадаа 40%-д үндэсний бүтээл орсон байхыг шаарддаг байна. Итали улс мөн 2011 оноос эхлэн Европын контентыг сурталчлах үүргийг тавьж эхэлсэн. Хойд Америк тивээс Канад улс

дотоодын контент хөгжүүлэх бодлогыг хамгийн идэвхтэй хэрэгжүүлж байгаа орнуудын нэг бөгөөд Монгол Улсад сайн жишиг болж чадах юм. Канад улсын хувьд дэлхийн өргөн нэвтрүүлгийн зах зээлд хамгийн хүчирхэг, хамгийн том байр суурь эзэлж буй АНУ-тай шууд хиллэлдэг орны хувьд дотоодын контентыг хамгаалах, сурталчлах нь өргөн нэвтрүүлгийн бодлогын хамгийн чухал зорилтуудын нэг болдог байна. Тухайлбал Үндэсний контент үйлдвэрлэлийг тусгай сан болон татварын хөнгөлөлтөөр дэмжих бодлого барьдаг. Мөн Швед болон Норвеги улсуудын хувьд НӨАТ-аас тодорхой хэмжээгээр хөнгөлөлт үзүүлдэг байна (Хууль зүйн үндэсний хүрээлэн).

Хуулийн зохицуулалт: АНУ-ын Конгресс 1992 онд “Кабелийн телевизийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай” хууль баталж, телевизийн сувгуудад “дахин дамжуулах зөвшөөрөл” (Retransmission Consent 21) эсвэл кабелийн системд сүлжээгээ төлбөргүйгээр дамжуулах систем (“Must-carry system”) гэсэн хоёр төрлөөс сонгож хэлэлцээр хийх боломж гаргаж ирсэн. Ингэснээр телевизүүд нь чанартай, шинэлэг контент бүтээх, чөлөөтэй үзэл бодлоо илэрхийлэх боломж олдож АНУ-ын өргөн нэвтрүүлгийн салбарт томоохон өөрчлөлт буюу “алтан үе”-ийг авчирсан байна. Зарим орнуудад Салбар дундын холбоо (Joint Industry Committee)-нд медиа салбарын асуудлыг даатгадаг байна. Үүнд бүх оролцогч талууд буюу зар сурталчилгаа нийлүүлэгчид, телевизүүд, ТВ цагийг борлуулдаг Sales house буюу IPTV үйлчилгээ эрхлэгчид зэргийг нэгтгэсэн холбоо юм. Арменид

Рекламны зөвлөл, Украинд Салбар дундын холбоо, Беларусьт Зар сурталчилгаа нийлүүлэгчдийн холбоо, Румынд Үзэгч хэмжилтийн Румыны холбоо, Англид телевизүүд болон зар сурталчилгаа нийлүүлэгчдийн холбоог нэгтгэсэн Үзэгч хэмжих өргөн нэвтрүүлэгчдийн холбоо (BARB) зэрэг байгууллагуудыг нэрлэж болно. (Максима Медиа ХХК, 2006)

Монголын Хэвлэлийн Хүрээлэн ЮНЕСКО-гийн Хэвлэл мэдээллийг хамгаалах олон улсын сангийн дэмжлэгтэйгээр “Хэвлэл мэдээллийн эрх зүйн форум”-ыг 2024.11.01-ны өдөр зохион байгуулсан. Форумын нэг панел хэлэлцүүлэг нь “Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын эрх зүйн асуудлууд” сэдвээр боллоо. Энэ үеэр Глоб интернэшнл төвийн хуульч Б.Пүрэвсүрэн дэлхийн бусад орнуудад өргөн нэвтрүүлгийн телевизүүдэд айл бүр хураамж төлдөг хуулийн зохицуулалт байдаг эсэхийг тодруулахад ХХЗХ-ны өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Н.Тогтохсүрэн “Өргөн нэвтрүүлгийн салбарын судалгааг 2012 оноос эхлээд хийсэн. Европын холбоо болон бусад орнуудад өргөн нэвтрүүлгийн зохицуулалтууд ямар байгааг судалж үзсэн. Яг өргөн нэвтрүүлгийн телевизүүд олон суваг дамжуулагчдаас “хураамж” хэлбэрийн төлбөр авч байгаа жишээ харахан байхгүй байна. Бусад оронд телевизүүд хөтөлбөрөө үнэлдэг жишиг бол байгаа. Харин хэрэглэгчээс “хураамж” авдаг жишиг хууль өргөн барих үед байгаагүй” гэж хариулсан.

Хэвлэл мэдээллийн салбарт 434, Өргөн нэвтрүүлгийн салбарт 241

оролцогч байхад нэр бүхий 18 телевизэд хуулиар бодлогын дэмжлэг үзүүлж, давуу байдал тогтоосон нь дэлхийд байхгүй жишиг болжээ. Тус 18 телевиз нь хувийн өмчит, ашгийн төлөө аж ахуй нэгжүүд боловч нийт үзэгчдээс “хураамж” авах болсон шалтгааныг тэдгээрийн эзэдтэй холбон тайлбарладаг. Улс төр, бизнест нөлөө бүхий хүмүүс өөрсдийн эзэмшдэг телевизэд давуу байдал олж авсан гэсэн таамаглал бий. Эзэмшлийн мэдээлэл ХХЗХ-ны веб сайтад ил тод байгаа бөгөөд 18 телевизийг УИХ, Засгийн газрын гишүүд, томоохон бизнес группийн захирлууд, тэдгээрийн хамаарал бүхий этгээдүүд эзэмшдэг болох нь тодорхой харагдана. Тэд улс төр дэх нөлөөгөө ашиглан Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийг лоббидож, батлуулсан байх боломжтой юм.

УИХ-ын даргын 2019.06.17-ны өдрийн 157 дугаар захирамжаар УИХ-ын гишүүн Д.Тогтохсүрэнгээр ахлуулан УИХ-ын гишүүн Б.Жавхлан, Ж.Мөнхбат, Л.Оюун-Эрдэнэ, О.Содбилэг нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн төсөл дээр ажиллажээ. Дээрх ажлын хэсэгт багтсан УИХ-ын гишүүдээс хожим Д.Тогтохсүрэн УИХ дахь МАН-ын бүлгийн дарга, Б.Жавхлан Сангийн сайд, Ж.Мөнхбат ЗГХЭГ-ын дарга, Л.Оюун-Эрдэнэ Ерөнхий сайд болсон бөгөөд тэдний улс төрийн карьерт ямар нэг хэлбэрээр ашигтай нөлөөлөл үзүүлсэн байхыг үгүйсгэхгүй юм. Мөн хууль батлагдах үед Монголын Телевизүүдийн Холбооны захирлаар ажиллаж байсан Г.Ганзул өдгөө Засгийн газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газрын

даргаар ажиллаж байна. ӨНТХ-иар дэмжлэг авсны хариуд телевизүүд төрөөс бэлтгэсэн нэвтрүүлгүүдийг нэг командаар цацдаг болсон гэх шүүмжлэл бий. Тухайлбал Ковид-19 цар тахлын үед “Мэдээллийн урсгал” нэртэй нэвтрүүлгийг 16 телевизээр цацахад 980 сая төгрөг зарцуулсан талаар тухайн үеийн Соёлын дэд сайд Ц.Батбаяр мэдээлж байв. “Олон нийтийн санаа бодлыг өөрчлөн манипуляци хийх явдал нь тоталитар болон авторитар дэглэмтэй улсуудад түгээмэл гэж зарим судлаачид үздэг боловч ардчилсан улсуудад ялангуяа сонгуулийн үед намуудын сурталчилгаанд байнга хэрэглэгддэг” (Томас Шерови) гэснийг батлах үйл явц мөн болсон. 2024 оны УИХ-ын сонгуулийн өмнө Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн оролцсон “Улаанбаатараас ярьж байна” нэвтрүүлэг, С.Зоригийн амь насыг хөнөөсөн асуудалтай холбогдох нэвтрүүлгийг өргөн нэвтрүүлгийн телевизүүдээр нэгэн зэрэг цацсан билээ. Дээрх нэвтрүүлгүүдийн гарах цагийг 14-18 телевизийн хөтөлбөрт нэгэн зэрэг тусгасан тухай зар мэдээллийг олон нийт хараад ихээхэн дургүйцэж байв. Максима Медиа ХХК-ийн мониторингийн тайланд 2022 оны эхний 6 сарын байдлаар телевизүүд зөвхөн төрөөс бэлтгэсэн мэдээ, нэвтрүүлгүүдийг 5 мянга орчим удаа нэвтрүүлсэн байна гэжээ. Эндээс үзвэл зөвхөн нэг урсгалт мэдээлэл буюу төрөөс бэлтгэсэн мэдээ, нэвтрүүлгийн тоо жилд 10 мянга орчимд хүрдэг байх магадлалтай юм. Үүнд олон хүчин зүйл нөлөөлж байгаа ч ӨНТХ-ийн үр дүнд төрөөс зарим хэвлэл мэдээллийн хэрэгсэлд давуу байдал олгох замаар эрхшээл,

нөлөөндөө оруулж, улс төрийн коммуникаци, үзэл суртлын дэд бүтэц болгосон нь чухал үүрэгтэй гэж үзэж байна. Улс төр судлаач Ф.Фукуяама “Албан ёсны голлох хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь улс төр, эдийн засгийн бүлэглэлүүд, эрх ашгаас хамааралтай бөгөөд бие даасан, хараат бус мэдээлэл, байр суурь илэрхийлэх чадавхгүй болсон пост-факт үе иржээ” (Fukuyama, 2017) хэмээн дүгнэснийг энд эш татах нь зүйтэй юм. Өргөн нэвтрүүлгийн тухай хууль нь улс төрийн мэдээлэл харилцаа, пропаганда, хэвлэл мэдээллийн хэт давуу байдал, иргэдийн мэдэх, сонгох, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, ардчиллын суурь зарчим олон ургальч үзэл зэрэгтэй холбогдох сонирхолтой судлагдахуун болох нь дамжиггүй юм.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Fukuyama, F. (2017, January 12). *The Emergence of a Post-Fact World*. Retrieved from <https://www.projectsyndicate.org/onpoint/the-emergence-of-a-post-fact-world-by-francis-fukuyama-2017-01>
2. Korean information society development institute (2023). *Technical Cooperation and Policy Consultation on Broadcasting and Media in Mongolia*. Ulaanbaatar.
3. Lasswel.H. (1927). The Theory of Political Propaganda. *The American Political Science Review*, 21.
4. Хэвлэл мэдээллийн эрх зүйн форум-2024.
5. Галбаатар Л. (2024). Retrieved from Өргөн нэвтрүүлгийн тухай хууль: <https://www.youtube.com/watch?v=6YyZEIeiB5w&t=748s>
6. Золжаргал Э. (2023). Retrieved from Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ: <http://www.sudalgaa.gov.mn>
7. Зулькафиль М. (2010). Монголын олон нийтийн мэдээлэл: Нэг намын үзэл суртлаас олон ургальч үзэл хүртэл. *Нэг сэдэвт зохиол*, 189-190.
8. Максима Медиа ХХК. (2006). *Телевизийн салбарын зах зээлийн зохицуулалтад гүйцэтгэх үзэгчийн судалгааны ач холбогдол*, үүрэг.
9. Мөнхбат С, Б. Д. (2002). Монгол дахь ардчилал: Иргэний улс төрийн оролцоо ба хэвлэл мэдээллийн хэрэгсэл. *Политологи* № 13, 191.
10. Мөнхмандах М. (2023). Retrieved from "Өргөн нэвтрүүлгийн тухай" хууль - шударга өрсөлдөөн, иргэний эрх: <https://www.youtube.com/watch?v=IGomtCOuzwg>
11. Мөнхцэцэг Ц. (2002). Улс төрийн манипуляци. *Политологи*.
12. Мэргэн Б. (2024). Retrieved from Өргөн нэвтрүүлгийн тухай хууль: <https://www.youtube.com/watch?v=6YyZEIeiB5w&t=748s>
13. Нарантуяа Г. (2023). Retrieved from <https://www.youtube.com/watch?v=IGomtCOuzwg>
14. Оюунбат Д. (2023). Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн шинжилгээ.
15. Ундрал Г. (2023). Retrieved from "Өргөн нэвтрүүлгийн тухай" хууль - шударга өрсөлдөөн, иргэний эрх: <https://www.youtube.com/watch?v=IGomtCOuzwg>
16. Хууль зүйн хүрээлэн. *Хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай хуулийн төслийн судалгаа*.
17. Шерови, Т. Дижитал эриний улс төрийн коммуникаци. *Политологи*.
18. Э.Хосбаяр. (2022). Хэвлэл мэдээллийн байгууллагын эзэмшлийн байдалд анализ хийх нь.

Summary

This paper explains Mongolian example that using mass medias as a tool to influence public opinion under the Broadcasting Law. In 2019, amendments to the Broadcasting Law allowed 18 commercial televisions to collect “fees” from “viewers”. However, in other countries there is no such standard that state pay legal fees for non-public, privately owned media outlets. This non-standard regulations are compared with how broadcasting is supported in other countries.

In addition to conducting qualitative interviews with stakeholders about the Broadcasting Law, this study analyzed whether commercial television stations are fulfilling their legal obligations. It also compared how broadcasting is supported in other countries around the world.

Keywords: Broadcasting Law, commercial television, privileges, fees, viewers, monopoly.